

## **“ДҮҮРЭГ, ХОРООДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### 1. Ерөнхий зүйл

1.1 “Дүүрэг, хороодын хөгжлийн зөвлөл” нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг, Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

1.2 Зөвлөлийн үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод байна.

### 2. Зорилго, Зорилт

2.1 Эрхэм зорилго- Налайх дүүрэг, хороодын бүтээн байгуулалт, хөгжлийн бүхий л үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

2.2. Иргэдийг аливаа хөгжлийн үйл ажиллагаанд уриалан манлайлагч, иргэдийн идэвх оролцоог дэмжигч дуу хоолой нь Хөгжлийн зөвлөл байна.

2.3. Эрхэм зорилго доо хүрэхийн тулд дараах зорилтуудыг тавьж ажиллана.

2.3.1. Хорооны “Хөгжлийн зөвлөл” нь хорооны иргэдтэй хамтран тэдний ая тухтай амьдрах орчин нөхцлийг сайжруулах талаар тулгамдаж буй асуудлуудыг судлан, төлөвлөгөө гарган

шийдвэрлүүлэх,

2.3.2. Тухайн хороонд хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон хөгжлийн бүхий л үйл ажиллагааны талаар төр, захиргааны удирдах байгууллагуудыг хурдан шуурхай, үр ашигтай, хариуцлагатай, ил тод шийдвэр гаргахад зөвлөн дэмжих, өөрсдийн оролцож гаргасан санал, зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих боломжоор хангагдах

2.3.3. Дээрхи асуудлыг дэвшүүлэхдээ иргэдээс цахим орчинд болон бусад хэлбэрээр санал асуулга авах, хурал хэлэлцүүлэг хийх

2.3.4. Нийгэм, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологийн шинэ ололт, амжилтын талаар дүүргийн иргэдэд таниулан сурталчлах, дүүргийн хөгжилд зөв зохистойгоор хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх.

3. Бүтэц, зохион байгуулалт болон ажиллах нөхцөл, журам.

3.1 Хорооны “Хөгжлийн Зөвлөл”:

3.1.1 Хорооны “Хөгжлийн Зөвлөл” нь Иргэдийн Нийтийн Хурлын дэргэдэх байна.

3.1.2 Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн нь 2 жилийн хугацаатайгаар хорооны хэсэг тус бүрээс (ИНХ-ын тэргүүлэгч байж болно) салбар бүрийн мэргэжлийн идэвх санаачлагатай, нас насны төлөөлөл оролцсон холимог, хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэн байхаар иргэдээс 9-15 хүний бүрэлдэхүүнтэй сонгогдоно. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1-2 Төлөөлөгч байна.

3.1.3 Хорооны иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгч нь хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүн байж болно.

3.1.4 Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүн нь тухайн хорооны эрх ашиг, сонирхлыг нэн тэргүүнд илэрхийлнэ.

3.1.5 Иргэдийн Нийтийн Хурлын дарга нь Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн дарга байж болно.

3.1.6 Хөгжлийн зөвлөл” нь хорооны иргэдийн Нийтийн Хурлын танхимд үйл ажиллагаагаа явуулна

3.1.7 Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн ажиллах боломжийг тухайн хорооны Засаг дарга болон түүний ажлын алба хангана. (Хорооны Засаг дарга болон зохион байгуулагчийн үр дүнгийн гэрээ, ажил үүргийн хуваарьт тусгаж болно.)

3.1.8 Хорооны “Хөгжлийн зөвлөл” нь тухайн хороонд үйл ажиллагаа явуулж буй бүхий л байгууллагад санал, зөвлөмж гаргах эрхтэй.

3.1.9 Тухайн хороонд хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон хөгжлийн бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан, байгууллага, хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган ажиллана.

3.1.10 Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн шийдвэрийг хорооны иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, албан бланканд буулгаснаар баталгаажина.

3.1.11 Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүд улиралд унаа, хоолны зардалтай байж болно. Үүнийг төлөвлөгөө болон ажлын тайланг харгалзан дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид тогтооно.

3.1.12 “Хөгжлийн зөвлөл”-ийн холбогдох зардлыг ИТХ-ын төсөвт суулгана.

### 3.2 Дүүргийн “Хөгжлийн зөвлөл”

3.2.1 Дүүргийн “Хөгжлийн зөвлөл”-ийг 2 жилийн хугацаатайгаар хороо тус бүрээс 1 гишүүн сонгогдож, тэргүүнээ дотроосоо сонгодог байна.

3.2.2 Дүүргийн “Хөгжлийн зөвлөл”-ийг ажиллах нөхцөл боломжоор дүүргийн ИТХ хангана.

3.2.3 Дүүргийн “Хөгжлийн зөвлөл” нь ИТХ-ын иргэний танхимд үйл ажиллагаа явуулна.

3.2.4 Дүүргийн “Хөгжлийн зөвлөл” нь хороо тус бүрээс ирсэн асуудал бүрийг судлан хэлэлцэж, шийдвэрлэх боломжтой эсэхээр нь эрэмбэ дараалалд оруулан ажлын төлөвлөгөө гаргаж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотой хамтран шийдвэрлэнэ.

4. “Хөгжлийн зөвлөл”-ийн хуралдаан

4.1 “Хөгжлийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хэлэлцүүлэг, хуралдаан байх бөгөөдирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайланг улирал бүр дүүргийн Хөгжлийн зөвлөл, тухайн тойргоос сонгогдсон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчидтэй хамтран Тэргүүлэгчдэд тайлагнана.

4.1.1 Хорооны Хөгжлийн зөвлөл нь тайлангаа хагас, бүтэн жилээр хорооны ИНХ-д тайлагнана.

4.2. Дүүргийн хөгжлийн зөвлөлийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

4.2.1 Ээлжит хурлыг улиралбүрийн эхний сарын ажлын эхний өдөр хуралдуулж байна.

4.2.2 Шаардлагатай гэж үзвэл гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

4.2.3 Дүүргийн хөгжлийн зөвлөлийн хуралд гишүүдийн 1/2 нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцож, ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

4.2.4 Дүүргийн Хөгжлийн зөвлөл нь хороодын хөгжлийн зөвлөлийн тайланг нэгтгэн улиралд нэг удаа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар, жилд нэг удаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус тайлагнана.

4.2.5 Гишүүдийн саналын дүнг гишүүдийн нэрсээр гаргаж, шийдвэрт хавсаргаснаар шийдвэр албан ёсны болно.

5. “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх

5.1. Хорооны “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүнийг тухайн хорооны ИНХ-аар 2 жилийн хугацаатай сонгох бөгөөд сонгогдсон гишүүн улиран сонгогдох боломжтой.

5.2. “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүн орон нутгаас шилжин явсан, нас барсан, өөрийн хүсэлтээр гарсан, чөлөөлөгдсөн тохиолдолд хорооны Хөгжлийн зөвлөлийн даргын санал болгосноор “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

5.3 “Хөгжлийн зөвлөл”-ийн гишүүн хурал болон үйл ажиллагаагаа шалтгаангүйгээр 3-аас дээш удаа тасалсан тохиолдолд гишүүнээс чөлөөлнө.

6. “Хөгжлийн зөвлөл”-ийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай

6.1 “Хөгжлийн зөвлөл”-ийн ажиллах журамд өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах тухай Дүүргийн “Хөгжлийн зөвлөл”-ийн санал болгосноор Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.

7. Хэрэгжих хугацаа

7.1 Энэхүү журам батлагдсанөдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.